



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох

Утас: 70453799, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор: Т.Золоо, Т.Ариунсайхан

Утас: 70453721, Цахим хаяг: Zoloot@audit.gov.mn

Ariunsaikhant@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.03.15 № УВА-2026/004/НА-СТА-ТӨҮГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б		1.00	2.00
1	ХӨРӨНГӨ			
1.1	Эргэлтийн хөрөнгө			
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		10,001,209,753.50	2,317,404,710.87
1.1.2	Дансны авлага		4,687,844,964.34	5,782,268,741.77
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		102,687,614.35	1,054,470,518.69
1.1.4	Бусад авлага		304,346,688.34	261,497,868.05
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		0.00	0.00
1.1.6	Бараа материал		3,184,806,235.60	2,754,510,588.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		274,601,042.18	5,394,344,725.01
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		49,350,694,083.88	52,774,400,855.09
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		0.00	0.00
1.1.10			0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		67,906,190,382.19	70,338,898,008.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө		88,355,084,309.81	79,249,161,584.58
1.2.2	Биет бус хөрөнгө		3,119,859,206.31	2,918,081,841.02
1.2.3	Биологийн хөрөнгө		0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		778,152,336.36	357,084,955.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		870,450,678.76	870,450,678.76
1.2.9			0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		93,123,546,531.24	83,394,779,059.36
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		161,029,736,913.43	153,733,677,067.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		0.00	0.00
2.1	Өр төлбөр		0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг		431,276,096.34	2,910,443,028.81
2.1.1.2	Цалингийн өглөг		0.56	0.00
2.1.1.3	Татварын өр		3,981,649,595.65	919,128,740.66
2.1.1.4	НДШ-ийн өглөг		45,416.07	315,724.99
2.1.1.5	Богино хугацаат зээл		0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг		0.00	164,599,719.02
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		6,548,435,549.75	140,379,474.50
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)		0.00	0.00

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,551,334,837.79	300,345,069.80
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12		0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,512,741,496.77	4,435,211,757.78
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	
2.1.2.1	Урт хугацаат зээл	72,359,335,755.74	75,783,042,526.75
2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	832,321,258.61	843,141,917.03
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	73,191,657,014.35	76,626,184,443.78
2.2	Өр төлбөрийн нийт дүн	85,704,398,511.12	81,061,396,201.56
2.3	Эздийн өмч	0.00	
2.3.1	Өмч: - төрийн	70,812,147,954.59	53,842,510,988.83
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,509,599,095.45	6,509,599,095.45
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	17,524,560,089.65	28,250,565,371.32
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-19,520,968,737.38	-15,930,394,589.68
2.3.10		0.00	
2.3.11	Эздийн өмчийн дүн	75,325,338,402.31	72,672,280,865.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	161,029,736,913.43	153,733,677,067.48

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	54,460,596,054.92	84,128,535,389.79
2	Борлуулалтын өртөг	73,680,420,887.67	84,045,370,694.00
3	Нийт ашиг (алдагдал)	-19,219,824,832.75	83,164,695.79
4	Түрээсийн орлого		0.00
5	Хүүний орлого	77,800,349.60	46,332,880.24
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	52,717,565,159.24	12,547,342,636.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,278,003,450.04	6,635,514,423.62
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,399,609,936.76	4,829,472,194.17
11	Санхүүгийн зардал	182,827,224.92	166,352,363.71

12	Бусад зардал	593,774,447.56	606,879,596.90
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-660,621,900.70	-667,763,246.32
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-160,400,863.23	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	-36,363,633.18	3,716,868,397.50
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	21,263,939,219.70	3,487,726,785.08
19	Орлогын татварын зардал	3,791,731,495.94	385,869,951.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	17,472,207,723.76	3,101,856,833.43
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	17,472,207,723.76	3,101,856,833.43
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
26	Бусад олз (гарз)	0.00	0.00
27	Орлогын нийт дүн	17,472,207,723.76	3,101,856,833.43
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	104,295,949,908.84	79,406,818,449.95
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	33,553,798,481.23	53,171,049,893.74
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,048,397.00	2,299,894.00
	Буцаан авсан албан татвар	0.00	200,000.00
	Татаас, санхүүжилтийн орлого	62,767,130,000.00	12,800,000,000.00
	Бусад мөнгөн орлого	7,971,973,030.61	13,433,268,662.21
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	91,851,186,325.61	60,038,127,262.04
	Ажиллагчдад төлсөн	10,206,777,802.73	15,100,220,525.24
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,095,456,774.19	4,506,017,508.31
	Бараа материал худалдан авахад төлсөн	24,139,801,988.24	23,198,993,311.67
	Ашиглалтын зардалд төлсөн	18,179,739,070.81	675,524,331.23
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	398,588,900.88	536,533,186.20
	Хүүний төлбөрт төлсөн	1,425,861,614.48	6,468,158.37
	Татварын байгууллагад төлсөн	6,470,244,600.92	12,869,895,961.00
	Даатгалын төлбөрт төлсөн	148,008,357.39	10,737,450.00

	Бусад мөнгөн зарлага	27,786,707,215.97	3,133,736,830.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,444,763,583.23	19,368,691,187.91
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	88,654,440.71	52,360,030.31
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,500,000.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,669,680.00	6,050,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	77,484,760.71	46,310,030.31
	Хүлээн авсан ноогдол ашиг	0.00	0.00
		0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,234,658,294.15	27,094,677,152.57
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,174,613,994.05	15,237,776,167.03
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	64,500,000.00	147,604,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	11,707,731,894.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	995,544,300.10	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	1,564,191.54
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,146,003,853.44	-27,042,317,122.26
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		0.00
	Төрөл бүрийн хандив		0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		15,356,910.05
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		0.00
	Төлсөн ногдол ашиг		0.00
			0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-15,356,910.05
4.1	Валютын ханшийн зөрүү	13,709,050.05	5,177,801.75
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,312,468,779.84	-7,683,805,042.65
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	688,740,973.66	10,001,209,753.52
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,001,209,753.50	2,317,404,710.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	70,812,147,954.59	6,509,599,095.45	17,524,560,089.65	-19,520,968,737.38	75,325,338,402.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	2,197,541,696.96	2,197,541,696.96
Залруулсан үлдэгдэл	70,812,147,954.59	6,509,599,095.45	15,288,482,300.65	-36,993,176,461.14	55,617,052,889.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	17,469,948,158.77	17,469,948,158.77
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	2,236,077,789.00	0.00	2,236,077,789.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	70,812,147,954.59	6,509,599,095.45	17,524,560,089.65	-19,520,968,737.38	75,325,338,402.31
2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	70,812,147,954.59	6,509,599,095.45	17,524,560,089.65	-19,520,968,737.38	75,325,338,402.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	488,717,314.27	488,717,314.27
Залруулсан үлдэгдэл	70,812,147,954.59	6,509,599,095.45	17,524,560,089.65	-19,032,251,423.11	75,814,055,716.58
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	3,101,856,833.43	3,101,856,833.43
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	-16,969,636,965.76	0.00	10,726,005,281.67	0.00	-6,243,631,684.09
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний	0.00	0.00	0.00	0.00	0.00

нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,842,510,988.83	6,509,599,095.45	28,250,565,371.32	-15,930,394,589.68	72,672,280,865.92

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		өөрчлөлт	
				төлөв	гүйц	биет	хувь
1	НИЙТ ЦЭХ	мян.кВт	305,312.2	332,872.7	332,477.9	-394.8	-0.1
	Үүнээс: ОХУ-аас худалдан авсан	мян.кВт	229,881.9	256,704.2	264,538.7	7,834.5	3.1
	БНХАУ-аас худалдан авсан	мян.кВт	11,766.5	12,593.8	14,846.6	2,252.8	17.9
	Дөргөний УЦС-ын үйлдвэрлэсэн	мян.кВт	42,660.2	40,979.7	29,734.6	11,245.1	-27.4
	Ховд Нар НЦС -ын үйлдвэрлэсэн	мян.кВт	21,003.6	22,595.0	23,358.0	763.0	3.4
2	Дотоод хэрэгцээний ЦЭХ	мян.кВт	3,911.9	3,828.1	3,110.6	-717.4	-18.7
		хувь	6.1	6.0	5.9	-0.2	-2.7
3	Дамжуулалтад авсан ЦЭХ	мян.кВт	301,400.3	329,044.6	329,367.2	322.6	0.1
4	Дамжуулалтын алдагдал	мян.кВт	24,454.8	27,613.5	28,070.1	456.5	1.7
		хувь	8.1	8.4	8.5	0.1	1.6
	Түгээлтийн алдагдал	мян.кВт	25,518.0	26,227.8	29,939.9	3,712.2	14.2
		хувь	13.6	12.7	14.8	2.1	16.1
	Дамжуулалт, түгээлтийн нийт алдагдал	мян.кВт	49,972.8	53,841.3	58,010.0	4,168.7	7.7
хувь		16.6	16.4	17.6	1.2	7.6	
5	Борлуулсан ЦЭХ	мян.кВт	251,427.5	275,203.4	271,357.2	-3,846.1	-1.4
6	Нийт орлого	сая.төг	50,333.9	98,808.9	82,162.2	16,646.7	-16.8
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая.төг	44,348.3	73,499.3	77,494.7	3,995.4	5.4
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	5,985.6	25,309.6	4,667.5	20,642.1	-81.6
7	Нийт зардал	сая.төг	77,730.1	110,966.8	97,337.2	13,629.6	-12.3
	Үүнээс: ЦЭХ-ний зардал	сая.төг	40,636.7	63,454.5	42,900.8	20,553.7	-32.4
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	35,796.3	44,854.3	54,150.0	9,295.7	20.7
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1,297.1	2,658.1	286.4	-2,371.7	0.0
8	Нийт ашиг алдагдал	сая.төг	-27,396.2	-12,158.0	-15,175.1	-3,017.1	24.8
	Улсын төсвийн татаас	сая.төг	46,809.7	6,628.0	18,276.9	11,648.9	175.8
	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	19,413.5	-5,530.0	3,101.9	8,631.8	156.1
	Татварын дараах ашиг, алдагдал	сая.төг	17,472.2	-5,530.0	2,791.7	8,321.6	150.5
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.8002	1.0524	0.9691	-0.1	-7.9
10	Нийт өглөг	сая.төг	85,704.4	91,754.6	81,061.4	10,693.2	-11.7
	Үүнээс: богино хугацаат өглөг	сая.төг	12,512.7	1,146.6	4,435.2	3,288.6	286.8
	Урт хугацаат өглөг	сая.төг	73,191.7	90,608.0	76,626.2	13,981.8	-15.4
11	Нийт авлага	сая.төг	5,094.8	1,109.1	7,098.2	5,989.1	540.0
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	сая.төг	5,542.3	20,812.8	16,544.4	-4,268.4	-20.5
13	Ажиллагсдын тоо	хүн	441.0	468.0	459.0	-9.0	-1.9
14	Нийт цалингийн сан	сая.төг	13,462.3	17,675.8	17,310.9	-364.9	-2.1
15	Борлуулалтын нэгжийн өртөг	төг/кВт.ц	309.2	403.2	358.7	-44.5	-11.0

16	Борлуулалтын дундаж үнэ /АУЭХС ТӨХК, Баян-Өлгий ЦШСГ орсон дүн/	төг/кВт.ц	176.4	267.1	285.6	18.5	6.9
17	Борлуулалтын өртөг, дундаж үнийн зөрүү	төг/кВт.ц	-132.8	-136.1	-73.1	63.0	-46.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн үйл ажиллагаа

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Цахилгаан эрчим хүч импортлох, үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах, түгээж борлуулах.

3.2 Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон.

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- ✓ Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн ерөнхий болоод тусгай бодлогод тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна. Иймээс НББОУС-д тусгасан бодлогын өөрчлөлтөд нийцэх үйл явдал үүсээгүй болно.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,296,059.8 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,001,209.75	2,317,404.71	-7,683,805.04
Авлага	5,094,879.26	7,098,237.11	2,003,357.85
Бараа материал	3,184,806.23	2,754,510.59	-430,295.64
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	274,601.04	5,394,344.73	5,119,743.69
Үндсэн хөрөнгө	92,253,095.86	82,524,328.38	-9,728,767.48
Хойшлогдсон татварын хөрөнгө	870,450.68	870,450.68	0.00
Бусад эргэлтийн хөрөнгө	49,350,694.08	52,774,400.90	3,423,706.82
Нийт хөрөнгө	161,029,736.90	153,733,677.10	-7,296,059.80
Нийт өр төлбөр	85,704,398.51	81,061,396.16	-4,643,002.35
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	75,325,338.40	72,672,280.87	-2,653,057.53
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	161,029,736.90	153,733,677.10	-7,296,059.80

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,317,404.7 мянган төгрөг болж 7,683,805.0 мянган төгрөгөөр буурахад 2024 оны 12 дугаар сард Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын санхүүжилт 6,450,100.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан нь 2025 онд ажил нь хийгдсэнтэй холбоотой санхүүжилт олгосноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 7,098,237.1 мянган төгрөг болж 2,003,357.8 мянган төгрөгөөр өсөхөд Увс ЦТС ХХК, Ховд ЦТС ХХК-ийн борлуулсан цахилгаан эрчим хүчний авлага өссөнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 2,754,510.6 мянган төгрөг болж 430,295.6 мянган төгрөгөөр буурахад сэлбэг хэрэгсэл болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны материалын зарцуулалт нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 82,524,328.38 мянган төгрөг болж, 9,728,767.48 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 605 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 469 нэр төрлийн нийт 31,660,667.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, 14,687,748.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Баруун бүс дахь салбарт шилжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Дээрх хөрөнгийг шилжүүлэхдээ дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 81,061,396.1 мянган төгрөг болж 4,643,002.3 мянган төгрөгөөр буурсан нь Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК ОХУ-аас импортолдог цахилгаан эрчим хүчний өр төлбөрийг Диспетчерийн үндэсний төвд Монгол улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/260 тушаалыг үндэслэн өр төлбөрийг шилжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 72,672,280.8 мянган төгрөг болж 2,653,057.5 мянган төгрөгөөр нэмэгдэхэд тайлант үеийн ашиг нөлөөлсөн байна.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүүгийн тайлан гаргадаг АРЕХ программ нь санхүүгийн тайлан гаргахдаа ББЭХС ТӨХК толгой компани дээр 4.29 төгрөг, Ховд ЦТС ХХК 0.24 мөнгө, Дөргөн УЦС ХХК нь 0.3 мөнгө, Увс ЦТС ХХК нь 0.03 мөнгө, нийт 4.86 төгрөгөөр санхүүгийн байдлын тайлан зөрүүтэй, өмчийн өөрчлөлтийн нэгтгэл тайлан 0.02 мөнгө, орлогын дэлгэрэнгүй тайлан дээр татвар төлөхийн өмнөх ашгийг 0.01 мөнгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэнийг аудитын явцад залруулсан болно.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/18 дугаар тушаалаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталж, 2025 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/201 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 82,162.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 97,337.2 сая төгрөгийн зардал гарган 15,175.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 82,162.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 16,646.7 сая төгрөг буюу 16.8 хувиар буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 97,337.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 13,629.6 сая төгрөг буюу 12.3 хувиар буурсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, Т.Ариунсайхан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл өндөр гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хувьд суурь үзүүлэлтийг 2025 оны нийт зардлаар сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг их гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 420,226.8 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 336,181.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь үндсэн үйл ажиллагаанд шаардлагатайгаас бусад зардал гаргасан зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15.1 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг зөрчин Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК нь спорт, уралдаан тэмцээнд 17,374.5 мянга, “Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК 7,172.0 мянга, нийт 24,546.5 мянган төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан байсанд зөрчлийг давтан гаргахгүй байхыг албан шаардлага өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 130 удаагийн 113,641,317.8 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 43 удаагийн 101,737,061.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээлэл, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 23,425,930.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэж зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь Шүүхийн шийдвэрийн дагуу засварын монтер Ж.Бат-Оргилд ажилгүй байсан хугацааны цалинд 18,609.8 мянган төгрөг, хэмжүүрийн инженер Ц.Баянмөнхөд 17,749.0 мянган төгрөгийг компанийн төсвөөс олгосон байна. Үүнд:

Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин олгосон судалгаа

Д/д	Нэрс	Огноо	Мөнгөн дүн /мян.төг/		Шүүхийн шийдвэр
			Цалин	НДШ	
1	Ж.Бат-Оргил	2025.05.20	18,609.8		2025.05.14, №01/ 917
2	Ц.Баянмөнх	2025.08.27	17,749.0		2025.08.13, № 01/1617
	Нийт дүн		36,358.0		

Төрд учирсан хохирлын дээрх асуудлыг Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", 50.2 дахь "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана" гэж заасны дагуу Төрийн албаны салбар зөвлөлд шилжүүлэхээр шийдвэрлэв.

2. Санхүүгийн тайлан дахь цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 2025 оны эхний үлдэгдэл 24,237.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 22,883.1 мянган төгрөгийн авлагатай байна. Харин цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланд 2025 оны эхний үлдэгдэл 19,209.6 мянган төгрөгийн авлагатай, эцсийн үлдэгдэл 4,046.2 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Санхүүгийн тайлан болон татварын тайлан дахь дээрх зөрүүг шалгуулахаар аймгийн Татварын газарт шилжүүлэхээр шийдвэрлэв.

3. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 58 дугаар тогтоолоор гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.14-т “Гүйцэтгэх захирал гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй бөгөөд бусад этгээдийн өмнө ажил, үүрэг гүйцэтгэхгүй байж, гэрээний биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө биечлэн хариуцах”, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 2.4-д “Компани нь хуулиар хориглоогүй бөгөөд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана” гэж заасан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь “Сувдан тамир электрик” ХХК-тай 2025 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн №АГГ25/08/04-010 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт байрлах “Ориент” ХХК-ийн уурхайн гадна шинээр баригдах цахилгаан хангамжийн 35 кВ-ын 37.3 км цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт хийх ажлыг 200.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулан

ажиллаж нийт 140.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Энэ асуудал нь цахим сүлжээнд нийтлэгдсэн мэдээлэл байсан ба ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй гэж үзэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэхээр шийдвэрлэв.

4. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйлчилгээнд ашигладаг Ланд-76 маркийн 06-88 УВХ улсын дугаартай автомашин нь 2025 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Увс аймгийн Сагил, Давст сумын нутагт Эрчим хүчний яамнаас ирсэн хүмүүсийн хамт шугамын зураг авалтын ажлаар явж байгаад унасан байна. Тухайн машиныг УБ хот руу тээвэрлэхэд “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн төсвөөс 980.0 мянган төгрөг гаргасан байна. Мөн холбогдох дүгнэлт гараагүй цагдаагийн газарт бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

Мөн “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйлчилгээнд ашигладаг Ланд-76 маркийн 01-44 УВС улсын дугаартай автомашиныг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Ховд, Баян-Өлгий аймгуудын машин механизмд техникийн хяналтын магадлан хийх ажлаар явж байгаад Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр Бураатын даваанд унагаасан байна. Мөн холбогдох байгууллагын дүгнэлт гараагүй, Цагдаагийн газарт бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй байна. Засвар үйлчилгээний зардалд “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-аас 17,440.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж хэрэгжүүлсэн горим сорилын дүнг баталгаажуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	14,175.0	3	14,175.0	100.0
Нийт дүн	3	14,175.0	3	14,175.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагад горим хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын нийт 238,968,050.2 мянган төгрөгийн 13 зөрчил илэрсэнд 4 зөвлөмж, 6 албан шаардлага, 3 төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна”, 6.3.2 дахь заалтад “Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт”, 6.3.3 дахь заалтад “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар”, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасан байхад Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 130 удаагийн 113,641,317.8 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 43 удаагийн 101,737,061.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний мэдээлэл, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 23,425,930.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

2.Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 3.1.3 дахь заалтад “Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог” гэж заасан байхад албан томилолтын мөнгө олгохдоо удирдамж, дуудсан албан бичиггүйгээр “Увс цахилгаан түгээх” ХХК нь 19,980.0 мянга, “Дөргөний усан цахилгаан станц” ХХК 2,100.0 мянга, нийт 22,080.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

3.Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана” гэж заасан байхад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 605 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 469 нэр төрлийн нийт 31,660,667.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, 14,687,748.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Баруун бүс дахь салбарт балансаас балансад шилжүүлэхдээ дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилжүүлсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өөрчлөлт оруулж бүртгэх.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2 дахь хэсэгт Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг зөрчин Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК нь спорт, уралдаан тэмцээнд 17,374.5 мянга, “Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК 7,172.0 мянга, “Дөргөний усан цахилгаан станц” ХХК бэлэг дурсгалын зардалд 720.0 мянга, спорт, уралдаан тэмцээнд 2,300.0 мянга, нийт 27,566.5 мянган төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

2. Илрүүлэлт

“Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн хүчин төгөлдөр анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй, 1,121.9 мянган төгрөгийн ачаа тээврийн хөлсийг иж бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3. Илрүүлэлт

Ховд цахилгаан түгээх ХХК нь сахилгын шийтгэлтэй нэр бүхий 7 албан хаагчдад 11,816.7 мянга, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь нэр бүхий 52 албан хаагчдад 98,028.2 мянга, нийт 59 албан хаагчид 109,844.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.3 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлтэй нэр бүхий 6 албан хаагчийн цалингийн тооцооллыг хийхдээ цалингийн цэсийн суутгал хэсэгт тооцож, 1,824.9 мянган төгрөгийг дутуу суутгасан, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 8 албан хаагчаас 690.2 мянган төгрөгийг дутуу суутгаж, 1 албан хаагчаас 45.8 мянган төгрөгийг илүү суутгасан байна.

Шийдвэрлэсэн нь:

Сахилгын шийтгэлтэй нэр бүхий 15 албан хаагчаас 2,515.1 мянган төгрөгийг суутгах, 1 албан хаагчаас илүү суутгасан 45.8 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. Илрүүлэлт

Ховд цахилгаан түгээх ХХК-ийн захирал нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 612.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж авсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон 612.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэл зөрүүтэй тооцсон	2	2,515.1	2	2,515.1								
Буцалтгүй тусламжийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй гээр олгосон	1	612.0	1	612.0								
Уралдаан тэмцээний зардал гаргасан.	3	27,566.5					3	27,566.5				

Анхан шатны баримтын бүрдэл дутуу	3	23,201.9			1	1,121.9	2	22,080.0			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	1	0.0					1	0.0			
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон.	2	109,844.9			2	109,844.9					
нийт	12	163,740.4	3	3,127.1	6	138,533.3	3	22,080.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хууль зөрчсөн	1	238,804,309.8					1	238,804,309.8
Дүн	1	238,804,309.8					1	238,804,309.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	238,804,309.8					1	238,804,309.8

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

Ч.МӨНХТОГТОХ/

Л.ЗОЛОО/

Г.АРИУНСАЙХАН/

2026 оны 03 сарын 15-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

03/26/А-2026/17
Дугаар УВА-2026/004/НА-СТА-ТӨНТ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлтэй нэр бүхий 6 албан хаагчийн цалингийн тооцооллыг хийхдээ цалингийн цэсийн суутгал хэсэгт тооцож, 1,824,965 төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт “Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна”, 123.2.3 дахь заалтад “Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7 дахь заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зөрүүтэй суутгасан 1,824,965 /нэг сая найман зуун хорин дөрвөн мянга есөн зуун жаран тав/ төгрөгийг холбогдох албан хаагчдаас суутгаж Ув.МХГазар-орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

- Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн захирал Л.Мөнхнаран, Ховд цахилгаан түгээх салбарын дарга С.Гантөмөр, нягтлан бодогч Н.Шинэжил нарт хариуцуулав.
- Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Т.Золоо

Т.ЗОЛОО

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03/26/A2070414-УВА-2026/004/НА-СТА-ТӨҮГ дугаар төлбөрийн актын хавсралт



Байгууллагын нэр: Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК

/төгрөг/

№	Нэрс	Дутуу суутгасан
1	Б.Буяннэмэх	499,853
2	Т.Жанцан	328,111
3	Б.Пүрэвдаваа	111,843
4	Х.Ризабек	294,507
5	С.Серикжан	326,011
6	Г.Султан	264,640
	Нийт	1,824,965



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

0112/2026/1092
Дугаар УВА-2026/ООН/НА-СТА-ТӨВГ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлтэй нэр бүхий 9 албан хаагчийн цалингийн тооцооллыг хийхдээ цалингийн цэсийн суутгал хэсэгт тооцож, 8 албан хаагчаас 690,231 төгрөгийг дутуу суутгаж, 1 албан хаагчаас 45,849 төгрөгийг илүү суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт “Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна”, 123.2.3 дахь заалтад “Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.7 дахь заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү суутгасан 45,849 /дөчин таван мянга найман зуун дөчин ес/ төгрөгийг 1 албан хаагчид олгож, дутуу суутгасан 690,231 /зургаан зуун ерэн мянга хоёр

зуун гучин нэг/ төгрөгийг 8 албан хаагчаас суутгаж Ув.МХГазар-орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн захирал Л.Мөнхнаран, ерөнхий нягтлан бодогч О.Булган нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Т.АРИУНСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БАТСУУРЬ



Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/24/А2071092-УВА-2026/004/НА-СТА-ТӨҮГ дугаар төлбөрийн актын хавсралт

Байгууллагын нэр: Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК

№	Нэрс	Дутуу суутгасан	Илүү суутгасан	Нийт
1	А.Чулуунбат	89,936		89,936
2	Б.Даваабуюн	370,790		370,790
3	Б.Цэвээнравдан	8,993		8,993
4	М.Батсүх		45,849	45,849
5	М.Гансүмбэр	31,167		31,167
6	С.Барсболд	77,789		77,789
7	Ц.Батчулуун	20,539		20,539
8	Ч.Отгончимэг	6,637		6,637
9	Б.Даваадорж	84,380		84,380
	Нийт	690,231	45,849	736,080

/төгрөг/



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 02/25/А-2070/НН
Д/А-2026/ООН/НА-СТА-ТӨҮТ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 612,000 төгрөгийн буцалтгүй тусламж авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон буцалтгүй тусламжийн 612,000 /зургаан зуун арван хоёр мянга/ төгрөгийг дарга С.Гантөмөрөөр төлүүлж Ув.МХГазар-орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн захирал Л.Мөнхнаран, Ховд цахилгаан түгээх салбарын нягтлан бодогч Н.Шинэжил нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

T. Zoloo

Т.ЗОЛОО

АУДИТЫН МЕНЕЖЕР



M. Bat-Amgalan
М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

M. Bat-Cuury

М.БАТЦУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

05/52/2071092
Дугаар УБА-2026/00Н/НА-СА-ТӨҮГ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Дөргөний усан цахилгаан станц” ХХК нь гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Б/19 дүгээр тушаалаар 2,300,000 төгрөгийн тэмцээн, уралдааны зардал, тушаал шийдвэргүйгээр 720,000 төгрөгийн бэлэг дурсгалын зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, компанийн төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Сэргээгдэх эрчим хүчний салбарын дарга Д.Алтансүх, ерөнхий нягтлан бодогч Д.Дариймаа нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т.АРИУНСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

02149/А-2070/114
Дугаар УВА-2026/004/НА-СТА ТӨНТ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/32 дугаар тушаалаар 2,520,000 төгрөг, 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Б/76 дугаар тушаалаар 6,500,000 төгрөг, 2025 оны 12 дугаар сарын 15-ны А/97 дугаар тушаалаар 7,434,500 төгрөг, гүйцэтгэх захирлын шийдвэргүйгээр 920,000 төгрөг, нийт 17,374,500 төгрөгийн спортын уралдаан тэмцээний зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, компанийн төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Ховд цахилгаан түгээх салбарын дарга С.Гантөмөр, нягтлан бодогч Н.Шинэжил нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т. Золоо

Т.ЗОЛОО

АУДИТЫН МЕНЕЖЕР

М. Бат-Амгалан

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М. Батсуурь

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 01/48/А 2020 414
УВА - 2026/004/НА-СТА - ТӨҮГ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь сахилгын шийтгэлтэй нэр бүхий 7 албан хаагчид 11,816,771 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт “Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна”, 123.8 дахь хэсэгт “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, 123.9 дэх хэсэгт “Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7 дахь заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Цахилгаан түгээх сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 05 дугаар сарын 01-ний А/42 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтнуудад сарын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.1-д “Сарын үр дүнгийн шагналыг дараах нөхцөлд олгохгүй”, 4.1.1-д “Сахилгын зөрчил гаргаж хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авагдсан” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Ховд цахилгаан түгээх салбарын дарга С.Гантөмөр, нягтлан бодогч Н.Шинэжил нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т.Золоо

Т.ЗОЛОО

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.Бат-Амгалан
М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.Батсуурь
М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 06/53/207092
УБА-2026/004/НА-СТА-ТӨНТ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь сахилгын шийтгэлтэй нэр бүхий 52 албан хаагчид 98,028,163 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт “Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна”, 123.8 дахь хэсэгт “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, 123.9 дэх хэсэгт “Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7 дахь заалтад “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах”, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 08 дугаар сарын 31-ний А/86 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр шагнал олгох журам”-ын 4-д “Доор дурдсан шалтгаан нөхцөлийн улмаас сарын үр дүнгийн шагнал олгохгүй”, б. Хөдөлмөрийн сахилгыг удаа дараа зөрчсөн, сахилгын арга хэмжээ авагдсан” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн захирал Л.Мөнхнаран, ерөнхий нягтлан бодогч О.Булган нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Т.АРИУНСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 03/50 /А 2020/115
УВА - 2026/004/НН/СТА - ТӨХК

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн хүчин төгөлдөр анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 1,121,900 төгрөгийн ачаа тээврийн хөлсийг иж бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10 дахь заалтад “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Иж бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил, гүйлгээ хийхгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Увс цахилгаан түгээх салбарын дарга Ж.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Өнөрдулам нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар ^{04/51/A2070445}
~~УВА-2026/004-СГА-70VI~~

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар 7,172,000 төгрөгийн спортын уралдаан тэмцээний зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3 дахь заалтад “Банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8 дахь заалтад “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, компанийн төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Увс цахилгаан түгээх салбарын дарга Ж.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Х.Өнөрдулам нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ